

ҮСГ-ын даргын 2008 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 01/9 тоот тушаалаар батлав.

## ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ГАЗАР



# Аялал жуулчлалын статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал

Улаанбаатар хот  
2008 он

# АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, ТЭДГЭЭРИЙГ ТООЦОХ АРГАЧЛАЛ

## Нэг. Нийтлэг үндэслэл

Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллага, иргэд болон мэдээллийг боловсруулагч, хэрэглэгчдэд статистикийн үзүүлэлтүүдийн тогтолцоо, тэдгээрийн тухай ойлголт, тодорхойлолтыг нэг мөр болгох мэдээлэл цуглуулах, боловсруулах, түүний үр дүнг судалгаа шинжилгээний ажилд ашиглах, нэгдсэн арга зүйг тогтооход энэхүү аргачлалын зорилго оршино.

Аялал жуулчлалын салбарт эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал 3.1-ийн 6305 дэд бүлэг буюу аялал жуулчлалтай холбоо бүхий үйл ажиллагааг хамруулна.

Нөгөө талаас өөрийн байнга оршин суудаг газар нутгаасаа 183 хоног хүртэлх хугацаагаар амралт, сувилал, танин мэдэхүйн зорилгоор болон шашин шүтлэг, ажил мэргэжлийн шугамаар айлчлах, хурал зөвөлгөөнд суух, дамжин өнгөрөх, суралцахаар өөр газар нутагт аялан яваа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харъяалалгүй хүний үйл ажиллагааг хамруулна.

## Хоёр. Ойлголт, тодорхойлолт

Аргачлалд орсон нэр, томъёог дараахь байдлаар ойлгоно (Эх үүсвэр: Нэгдсэн Үндэсний Байгууллагын Дэлхийн Аялал жуулчлалын байгууллагаас гаргасан “Аялал жуулчлалын статистикийн олон улсын зөвлөмж-2000”; Зам, тээвэр, аялал жуулчлалын Яам, Хууль зүй, дотоод хэргийн Яамнаас хамтран гаргасан “Аялал жуулчлалтай холбогдсон эрх зүйн баримт бичгийн эмхтгэл-2006 он”; “Аялал жуулчлал, байрны төрлийн үндсэн нэр томъёо”, Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төв, Улаанбаатар хот, 2004 он). Үүнд:

2.1. Байнгын оршин суугч гадаадын иргэн гэж тухайн нутаг дэвсгэрт 12 сараас багагүй хугацаагаар амьдарсан, тухайн нутаг дэвсгэрт богино хугацаагаар амьдарч байгаа бөгөөд гадаадад яваад 12 сарын дотор багтаан буцаж ирэн амьдрах зорилготой хүнийг /Дэлхийн Аялал Жуулчлалын Байгууллагаас гаргасан зөвлөмж Д-24/;

2.2. Аялал жуулчлалын төрөл гэж аялал жуулчлалын үйл ажиллагаа нь дотоодын аялал жуулчлал, гадаадаас хүлээн авах аялал жуулчлал, гадаадад явуулах аялал жуулчлал гэсэн 3 үндсэн төрлийг;

2.3. Дотоодын аялал жуулчлал (Domestic tourism) гэж тухайн улсын иргэн, байнгын оршин суугч гадаадын иргэн зөвхөн өөрийн улс орон дотроо хийх жуулчлалыг;

2.4. Гадаадаас хүлээн авах аялал жуулчлал (Inbound tourism) гэж өөр улсад байнга оршин суугч тухайн улсад хийх жуулчлалыг;

2.5. Гадаадад явуулах аялал жуулчлал (Outbound tourism) гэж тухайн улсын иргэн, байнгын оршин суугч гадаадын иргэн өөрийн улс орноос гадагш өөр улс орон руу хийх жуулчлалыг;

2.6. Улс доторхи аялал жуулчлал (Internal tourism) гэж дотоодын болон гадаадаас хүлээн авах аялал жуулчлалыг хамрах ба энэ нь байнгын оршин суугчид болон байнгын бус оршин суугчдын өөрийн орон нутагт аялах жуулчлалыг;

2.7. Үндэсний аялал жуулчлал (National tourism) гэж дотоодын болон гадаадад явуулах аялал жуулчлалыг хамрах ба байнгын оршин суугч өөрийн орон нутагт болон олон улсад аялах жуулчлалыг;

2.8. Олон улсын аялал жуулчлал (International tourism) гэж гадаадаас хүлээн авах аялал жуулчлал болон гадаадад явуулах аялал жуулчлалыг хамрах ба энэ нь байнгын оршин суугч болон байнгын бус оршин суугчдын өөрийн орон нутагт болон олон улсад аялах жуулчлалыг;

2.9. Дамжин өнгөрөх зорчигч гэж ямар нэг аяллын зорилгогүйгээр нэг газар нутгаас нөгөө газар нутагт хүрэх замдаа буудаллан өнгөрсөн зорчигчийг;

2.10. Иж бүрэн аялал гэж аяллын үйлчилгээнд багтдаг голлох үйлчилгээ, тухайлбал, тээвэр, байр, хоол, үзвэр, тухайлсан идэвхитэй үйл ажиллагаа зэргийг тур оператор буюу аялал зохион байгуулагч өмнө нь төлөвлөн бэлтгэж нэг үнээр багцлан үйлчлүүлэгчдэд санал болгох аяллыг;

2.11. Бүлэг аялал гэж иж бүрэн аялал, үйлчлүүлэгчид тусгайлан зориулсан аялал, хурал, зөвлөгөөний аялал, урамшууллын аялал, тогтсон хуваарийн дагуу хийх аялал, танилцуулах аялал зэрэг хэлбэрийг багтаасан аяллыг;

2.12. Хувийн аялал гэж тухайн жуулчин иж бүрэн аялалд хамрагдаагүй, мөн ямар нэгэн аялал жуулчлалын байгууллагаар зуучлуулаагүйгээр өөрөө зохион байгуулсан аяллыг;

2.13. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн гэж аялал жуулчлалын байгууллагаас үзүүлж байгаа жуулчдын сонирхлыг татах, тэдний аялах тав тухтай нөхцлийг хангасан төлбөрт үйлчилгээг;

2.14 Гийчин гэж өөрийн байнга оршин суудаг газраас өөр газарт 183 хоногоос хэтрэхгүй хугацаагаар ашиг, хөлс олох үйл ажиллагаанаас бусад зорилгоор аялж яваа хувь хүнийг;

2.15 Аяллын зорилго. Аялж буй жуулчныг аяллын зорилгоор нь 2 ангилна. Үүнд:

- а) Ажил хэргийн,
- б) Хувийн, Үүнд:
  - Баяр ёслолд оролцох, амралт, зугаалгаар
  - Найз нөхөд, хамаатныдаа зочлох

- Боловсролоо дээшлүүлэх, сургалтанд оролцох
- Эрүүл мэндээ сайжруулах
- Шашин мөргөл үйлдэх
- Эд бараа худалдаж авах
- Дамжин өнгөрөх
- Бусад

а) *Ажил хэргийн аялал жуулчлал.* Уулзалт, зөвлөгөөнд оролцох, үзэсгэлэн худалдаа гаргах, оролцох, лекц унших, концерт жүжиг, шоунд оролцох тоглох, бараа зарах, арилжих, гадаадын үйлдвэрлэгчийн өмнөөс үйлчилгээ үзүүлэх, судалгаа, шинжилгээний ажил хийх, оролцох, аялал, жуулчлалын хөтөлбөрүүд болон мэргэжлийн спортын үйл ажиллагаанд оролцох, газраар явдаг тээврийн хэрэгсэл, онгоц болон нийтийн тээврийн хэрэгслийн үйлчилгээний багийн гишүүн байх зэрэг нь ажил хэргийн шугамаар аялагч гэж үзнэ.

б) *Хувийн аялал жуулчлал.* Энэ бүлэгт а)-д зааснаас бусад бүх зорилго бүхий аялал жуулчлал багтана. Үүнд:

- *Баяр ёслолд оролцох, амралт, зугаалгаар аялах.* Энэ бүлэгт улс орны түүхэн дурсгалт, байгалийн болон хүний гараар бүтээгдсэн үзэсгэлэнт газрыг үзэх, спорт, урлагийн арга хэмжээнд оролцох (морь унах, тэмээ унах, гольф, теннис тоглох, явган аялах, ууланд аялах, ууланд авирах, урлагийн тоглолт үзэх гэх мэт.), мэргэжлийн бус спортын үйл ажиллагаанд оролцох, амралт зугаалга үзвэр үйлчилгээний газруудад цагаа өнгөрөөх, бал сараа тэмдэглэх, рашаан сувилал, иллэгийн газраар үйлчлүүлэх зэрэг хүнийг амрааж тайвшруулах газрууд, түүнчлэн биеийн тамирын дасгал сургууль хийх цэгүүдээр үйлчлүүлэх, амралтын байшинг урт, богино хугацаагаар түрээслэх, гэр бүлээрээ амралтаа өнгөрөөх зэрэг зорилгоорх аялал жуулчлал орно. Гэхдээ эмчилгээ сувилгааг энд хамруулахгүй.
- *Найз болон хамаатныдаа зочлох.* Энэ бүлэгт хамаатан, найзындаа зочлох; хуримын, оршуулгын ёслолд оролцох, мөн гэр бүлийн бусад арга хэмжээнд оролцох, өвчтэй болон настай хүн богино хугацаагаар харах зэрэг аялал хамаарна.
- *Боловсролоо дээшлүүлэх ба сургалтанд оролцох.* Тусгай ур чадварыг богино хугацаагаар эзэмших, ажлын байранд зохиогдох сургалт, мөн төлбөрт сургалт, хэлний, мэргэжлийн эсвэл тусгай сургалтанд суралцах (6 сараас бага хугацаатай байна), тусгай зориулалттай сургалтын хөтөлбөрүүдэд (албан ба албан бус) оролцох зэрэг үйл ажиллагааг оруулна.
- *Эрүүл мэндээ сайжруулах.* Энэ бүлэгт дараахь төрлийн үйл ажиллагааг тухайлбал, эмнэлэг сувиллын газар, клиник болон эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэх, амралтын газар болон эрүүл мэндийн зөвлөмжид суурилсан эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг тусгай үйлчилгээний газраар үйлчлүүлэх ажиллагааг хамруулна. Энэ

бүлэгт богино хугацааны эмчилгээ орно. Харин 183 хоногоос дээш хугацаа шаардах урт хугацааны эмчилгээг аялал жуулчлалын үйл ажиллагаанд тооцохгүй.

- *Шашин, мөргөл үйлдэх.* Энэ бүлэгт шашны хурал, уулзалт, мөргөл үйлдэх зэрэг үйл ажиллагааг хамруулна.
- *Эд бараа худалдаж авах.* Энэ бүлэгт хувийн хэрэгцээндээ зориулан өргөн хэрэглээний бараа, бэлэг худалдан авах үйл ажиллагааг хамруулах бөгөөд гэхдээ дахин худалдах, түүхий эд, материал болгох зорилгоор (энэ тохиолдол нь ажил хэргийн шугамаарх аялал болно) худалдан авах үйл ажиллагааг оруулахгүй.
- *Дамжин өнгөрөх.* Ямар нэг аяллын зорилгогүйгээр нэг газар нутгаас нөгөө газар нутагт хүрэх замдаа буудаллан өнгөрөх үйл ажиллагааг хамруулна.
- *Бусад.* Энэ бүлэгт сайн дураар ажил хийх, цагаачлал болон шилжин суурьших боломжийг судлах, мөн түүнчлэн цалин авах ажил эрхлэхээс бусад бүх үйл ажиллагааг тусгана.

2.16. Тур оператор (Tour operator) гэж аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг төлөвлөх, бүрдүүлэх, сурталчлах, бөөнөөр болон жижиглэнгээр худалдах, аялал зохион байгуулах, виз авахтай холбогдсон болон аяллын бусад бичиг баримтын бүрдүүлэлт хийх, онгоц, төмөр замын болон тээврийн хэрэгслээр зорчих билетийн захиалга хийх, билет худалдах, худалдан авах, зочид буудал, жуулчны бааз, байр, үзвэрийн захиалга хийх, жуулчныг угтан авах, үйлчлэх, үдэн гаргах үйл ажиллагааг эрхэлдэг иргэн, хуулийн этгээдийг;

2.17. Тур агент (Tour agent) гэж аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг төлөвлөх, бүрдүүлэх, сурталчлах, бөөнөөр болон жижиглэнгээр худалдах, аялал зохион байгуулахаас бусад тур операторын эрхлэх үйл ажиллагааг бүхэлд нь эсвэл түүний тодорхой хэсгийг, түүнчлэн тур операторын бүтээгдэхүүнийг зуучлан худалдах, худалдан авах үйл ажиллагааг эрхэлдэг иргэн, хуулийн этгээдийг;

2.18. Жуулчны бааз (Tourist camp) гэж орон нутагт байрласан, жуулчдын аялах тав тухтай нөхцлийг хангасан байр, хоолны болон бусад төлбөрт үйлчилгээ үзүүлдэг үйлчилгээний цогцолборыг;

2.19. Ангийн омог (Hunting camp) гэж агнуурын нөөц нутагт байрласан, анчид, жуулчдыг хүлээн авч байр, хоолны болон бусад шаардлагатай үйлчилгээ үзүүлдэг үйлчилгээний цогцолборыг авч үзнэ.

## Гурав. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТООЦОХ НЬ

3.1. Нийт зорчигчдын тоо. Улсын хилээр нэвтэрсэн гадаад, дотоодын нийт зорчигчдын тоог улсаар нь болон аяллын зорилгоор нь ангилан гаргана.

Нийт зорчигчдын тоог улсын хилээр орсон, гарсан гадаад, дотоодын зорчигчдын захиргааны статистик мэдээллээс (Хил хамгаалах асуудал хариуцсан газраас) боомтоор, аяллын зорилгоор, улсаар ангилж хагас жил болон жилийн давтамжтайгаар хүлээн авч мэдээлнэ.

3.2. Нийт зорчигчдын тоо, аяллын зорилгоор. Улсын хилээр нэвтэрсэн гадаад, дотоодын нийт зорчигчдын тоог энэ аргачлалын 2.15-д заасны дагуу аяллын зорилгоор ангилж гаргана.

3.3. Үйлчилгээ авсан жуулчдын тоо гэж аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд хүлээн авч үйлчилсэн жуулчдын тоог хэлнэ. Тайлант хугацаанд үйлчилгээ авсан нийт жуулчдын тоог аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагуудын тайлант хугацаанд үйлчилгээ авсан жуулчдын тооны нийлбэрээр гаргана.

Үйлчилгээ авсан нийт жуулчдыг дотоодын жуулчид, гадаадад явуулсан жуулчид, гадаадаас хүлээн авсан жуулчид гэж ангилна.

Энэ үзүүлэлтийг аялал жуулчлалын салбарын үйл ажиллагааны улирал, жилийн албан ёсны статистик (“Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын 20.. оны мэдээ”-АЖ-1, “Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын 20.. оны ... –р улирлын мэдээ”-АЖ-1а) мэдээллээс нэгтгэн гаргана.

Үйлчилгээ авсан нийт жуулчдын тоог (1) томъёогоор тодорхойлно. Үүнд:

$A$  = Үйлчилгээ авсан нийт жуулчдын тоо

$N$  = Аж ахуйн нэгж, байгууллагын нийт тоо

$B_i$  = Дотоодын жуулчдын тоо

$C_i$  = Гадаадад явуулсан жуулчдын тоо

$D_i$  = Гадаадаас хүлээн авсан жуулчдын тоо

$$A = \sum_{i=1}^N (B_i + C_i + D_i); \quad (1)$$

Тооцоог хийсвэр жишээгээр үзүүлбэл: Хөвсгөл аймгийн аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг 5 аж ахуйн нэгж, байгууллагын 2007 оны 3 дугаар улирлын мэдээ ирсэн гэж үзье.

ААНБ-ын нэр	Дотоодын жуулчдын тоо	Гадаадад явуулсан жуулчдын тоо	Гадаадаас хүлээн авсан жуулчдын тоо
Хөвсгөл трэйвэл	50	35	50
Хөвсгөл жуулчин	65	42	70
Ургах наран	45	10	90
Монголын нүүдэлчин ХХК	96	26	150
Монгол угсаа ХХК	120	18	230

Дээрх мэдээг үндэслэн Хөвсгөл аймгийн үйлчилгээ авсан нийт жуулчдын тоог тодорхойлбол:

$$A = \sum_{i=1}^5 (B_i + C_i + D_i) = (50 + 35 + 50) + (65 + 42 + 70) + \dots + (120 + 18 + 230) = 1097$$

Хөвсгөл аймгийн аж ахуйн нэгж, байгууллагын үйлчилгээ авсан нийт жуулчдын тоо 2007 оны 3 дугаар улиралд 1097 байна.

3.4. Дотоодын жуулчдын тоо -нд тухайн улсын байнгын оршин суугч нь өөрийн улс дотроо байнга оршин суудаг газар нутгаасаа өөр газар, нутагт амралт, баяр ёслол, албан ажлаар болон жуулчлалын бусад зорилгоор аялж байгаа тус улсын иргэдийг хамруулна.

Энэ үзүүлэлтийг аялал жуулчлалын салбарын үйл ажиллагааны улирал, жилийн албан ёсны статистик (“Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын 20.. оны мэдээ”-АЖ-1, “Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын 20.. оны ... –р улирлын мэдээ”-АЖ-1а) мэдээллээс нэгтгэн гаргана.

Нөгөө талаас өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны (1.10)-р үзүүлэлт буюу сүүлийн 12 сарын турш гэртээ эзгүй байсан өрхийн гишүүдийг, эзгүй байсан шалтгаанаар нь ангилан тооцож гаргах боломжтой.

3.5. Гадаадад явуулсан жуулчдын тоо -нд тур оператор болон тур агентын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн тайлант хугацаанд зохион байгуулж гадаадад явуулсан жуулчдыг хамруулна.

Гадаадад явуулсан жуулчдын тоог голлон явсан улс болон бусад гэж ангилан харуулна.

Энэ үзүүлэлтийг аялал жуулчлалын салбарын үйл ажиллагааны улирал, жилийн албан ёсны статистик (“Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын 20.. оны мэдээ”-АЖ-1, “Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын 20.. оны ... –р улирлын мэдээ”-АЖ-1а) мэдээллээс нэгтгэн гаргана.

3.6 Гадаадаас хүлээн авсан жуулчдын тоо -нд тайлант хугацаанд аялал жуулчлалын аж ахуйн нэгж, байгууллагын гадаадаас хүлээн авч үйлчилсэн

жуулчдыг хэлнэ. Гадаадаас хүлээн авсан жуулчдын тоог голлон хүлээн авсан улсаар ангилан харуулна.

Энэ үзүүлэлтийг аялал жуулчлалын салбарын үйл ажиллагааны улирал, жилийн албан ёсны статистик (“Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын 20.. оны мэдээ”-АЖ-1, “Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын 20.. оны ... –р улирлын мэдээ”-АЖ-1а) мэдээллээс нэгтгэн гаргана.

3.7 Зохион байгуулсан нийт аяллын тоо -нд тур оператор болон тур агентын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд жуулчдад зориулан зохион байгуулсан нийт аяллыг оруулах бөгөөд дотор нь дотоодын, гадаадад явсан, гадаадаас ирсэн жуулчдад зориулан зохион байгуулсан аялал гэж ангилан гаргана.

Энэ үзүүлэлтийг аялал жуулчлалын салбарын үйл ажиллагааны улирал, жилийн албан ёсны статистик (“Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын 20.. оны мэдээ”-АЖ-1, “Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын 20.. оны ... –р улирлын мэдээ”-АЖ-1а) мэдээллээс нэгтгэн гаргана.

3.8 Нийт орны тоо -нд аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулж байгаа жуулчны бааз, ангийн отгийн жуулчид хоноглоход зориулсан, бүх эд зүйлээр тоноглогдсон, дэлгээтэй, үйлчилгээнд бэлэн байгаа орыг хамруулна.

Энэ үзүүлэлтийг аялал жуулчлалын салбарын үйл ажиллагааны улирал, жилийн албан ёсны статистик (“Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын 20.. оны мэдээ”-АЖ-1, “Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын 20.. оны ... –р улирлын мэдээ”-АЖ-1а) мэдээллээс нэгтгэн гаргана.

3.9 Нийт өрөөний тоо –нд аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, игэдийн жуулчид хүлээн авч байрлуулахад зориулагдсан бэлэн байгаа өрөөг хамруулна.

Энэ үзүүлэлтийг аялал жуулчлалын салбарын үйл ажиллагааны улирал, жилийн албан ёсны статистик (“Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын 20.. оны мэдээ”-АЖ-1, “Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын 20.. оны ... –р улирлын мэдээ”-АЖ-1а) мэдээллээс нэгтгэн гаргана.

3.10 Жуулчдад үйлчилгээ үзүүлсэн хоногийн тоо-г тур оператор болон тур агентын жуулчдыг Монголд ирснээс эхлэн үдэж явуулах хүртэлх жуулчин тус бүрт үйлчилсэн хоногийн нийлбэрээр гаргана. Үүнд дотоодын жуулчин тус бүрт үйлчилсэн хоногийн тоо мөн орно.

Энэ үзүүлэлтийг аялал жуулчлалын салбарын үйл ажиллагааны улирал, жилийн албан ёсны статистик (“Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын 20.. оны мэдээ”-АЖ-1, “Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын 20.. оны ... –р улирлын мэдээ”-АЖ-1а) мэдээллээс нэгтгэн гаргана.

3.11 Жуулчдад үйлчилгээ үзүүлсэн ор хоногийн тоо-г жуулчны бааз болон ангийн отогийн хүлээн авсан жуулчин тус бүрт үйлчилсэн ор хоногийн нийлбэр буюу хүлээн авсан жуулчдын тоо болон хоносон хоногийн тооны үржвэрүүдийн нийлбэрээр гаргана.

Энэ үзүүлэлтийг аялал жуулчлалын салбарын үйл ажиллагааны улирал, жилийн албан ёсны статистик (“Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын 20.. оны мэдээ”-АЖ-1, “Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын 20.. оны ... –р улирлын мэдээ”-АЖ-1а) мэдээллээс нэгтгэн гаргана.

3.12. Үйл ажиллагаа явуулсан өдрийн тоо гэж тайлант хугацаанд жуулчдад зориулан үйлчилгээ явуулсан нийт өдрийг хэлнэ.

Тайлант хугацаанд үйл ажиллагаа явуулсан нийт өдрийн тоог аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа явуулсан өдрийн тооны нийлбэрээр гаргана. Үйл ажиллагаа явуулсан нийт өдрийн тоог аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн үйлчилгээний газрын төрлөөр ангилан гаргана.

Энэ үзүүлэлтийг аялал жуулчлалын салбарын үйл ажиллагааны улирал, жилийн албан ёсны статистик (“Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын 20.. оны мэдээ”-АЖ-1, “Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын 20.. оны ... –р улирлын мэдээ”-АЖ-1а) мэдээллээс нэгтгэн гаргана.

Тайлант хугацаанд үйлчилгээ үзүүлсэн нийт өдрийн тоог аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын тоонд харьцуулж аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагуудын тухайн хугацаанд үйлчилгээ явуулсан дундаж өдрийн тоог тооцно.

Үйлчилгээ явуулсан дундаж өдрийн тоог (2) томъёогоор тодорхойлно. Үүнд:

$\bar{X}_a$  = Үйлчилгээ явуулсан дундаж өдрийн тоо

$N$  = Аж ахуйн нэгж, байгууллагын тоо

$U_i$  = Үйлчилгээ явуулсан өдрийн тоо

$$\bar{X}_a = \frac{U}{N} = \frac{\sum_{i=1}^N U_i}{N} ; \quad (2)$$

Тооцоог хийсвэр жишээгээр үзүүлбэл: Хөвсгөл аймгийн жуулчны баазын үйл ажиллагаа эрхэлдэг 5 аж ахуйн нэгж, байгууллагын 2007 оны 3 дугаар улирлын мэдээ ирсэн гэж үзье.

ААНБ-ын нэр	Үйлчилгээ явуулсан өдрийн тоо
Хөвсгөл трэйвэл	90
Хөвсгөл жуулчин	85
Ургах наран	70
Монголын нүүдэлчин ХХК	45
Монгол угсаа ХХК	30

Дээрх мэдээг үндэслэн Хөвсгөл аймгийн жуулчны баазуудын үйлчилгээ явуулсан дундаж өдрийн тоог тодорхойлбол:

$$\bar{X}_a = \frac{U}{N} = \frac{\sum_{i=1}^N U_i}{N} = \frac{90 + 85 + 70 + 45 + 30}{5} = \frac{320}{5} = 64$$

Хөвсгөл аймгийн жуулчны баазуудын 2007 оны 3 дугаар улиралд үйлчилгээ явуулсан дундаж өдрийн тоо 64 байна.

3.13. Аялал жуулчлалын орлого гэж Монгол Улсад жуулчилж буй гадаадын иргэдээс тус улсын үндэсний тээвэрлэгчид /олон улсын тээвэрт/ төлсөн төлбөрийг оролцуулахгүйгээр аливаа үйлчилгээ болон бараа бүтээгдэхүүн худалдан авахад зориулан зарцуулсан мөнгөний хэмжээг хэлнэ.

Аялал жуулчлалын орлогыг хоёр төрлөөр тодорхойлно. Үүнд аялал жуулчлалын нийт орлого болон аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын жуулчдаас олсон орлого гэж ялган тооцно. Эдгээр орлогыг дараахь байдлаар тодорхойлно:

1. Аялал жуулчлалын нийт орлогыг Монгол Улсад ирж буй гадаадын жуулчдын тоо, нэг жуулчны тус улсад өнгөрөөж буй дундаж хугацаа, хоногт зарцуулж буй валютын дундаж хэмжээ гурвын үржвэр дүнгээр илэрхийлнэ.
2. Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын жуулчдаас олсон орлогыг эдгээр аж ахуйн нэгж, байгууллагын улирлын болон жилийн мэдээнээс авч нэгтгэн гаргана.

Аж ахуйн нэгж, байгууллагын жуулчдаас олсон орлогыг аялал жуулчлалын салбарын үйл ажиллагааны улирал, жилийн албан ёсны статистик (“Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын 20.. оны мэдээ”-АЖ-1, “Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын 20.. оны ... –р улирлын мэдээ”-АЖ-1а) мэдээллээс нэгтгэн гаргах бол аялал жуулчлалын нийт орлогыг түүвэр судалгааны үр дүнгээр тооцно.

3.14. Аялал жуулчлалын аж ахуйн нэгж, байгууллагын гадаадын жуулчдаас олсон орлого гэж аялал жуулчлалын аж ахуйн нэгж, байгууллагын гадаадын жуулчдад үйлчилгээ үзүүлж олсон орлогыг хамруулна.

Энэ үзүүлэлтийг аялал жуулчлалын салбарын үйл ажиллагааны улирал, жилийн албан ёсны статистик (“Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын 20.. оны мэдээ”-АЖ-1, “Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын 20.. оны ... –р улирлын мэдээ”-АЖ-1а) мэдээллээс нэгтгэн гаргана.

3.15. Гадаадын нэг жуулчинд ногдох аялал жуулчлалын аж ахуйн нэгж, байгууллагын дундаж орлого -д тайлант хугацаанд гадаадын жуулчдаас олсон аж ахуйн нэгж, байгууллагын нийт орлогын хэмжээг тухайн хугацаанд гадаадаас хүлээн авсан нийт жуулчдын тоонд харьцуулж гадаадын нэг жуулчинд ногдох аж ахуйн нэгж, байгууллагын дундаж орлогыг тооцно.

Энэ үзүүлэлтийг тооцоход шаардлагатай үзүүлэлтүүд буюу гадаадын жуулчдаас олсон нийт орлого болон гадаадаас хүлээн авсан жуулчдын тоог аялал жуулчлалын салбарын үйл ажиллагааны улирал, жилийн албан ёсны статистик (“Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын 20.. оны мэдээ”-АЖ-1, “Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын 20.. оны ... –р улирлын мэдээ”-АЖ-1а) мэдээллээс авч тооцно.

Гадаадын нэг жуулчинд ногдох ААНБ-ын дундаж орлогыг (3) томъёогоор тодорхойлно. Үүнд:

$\overline{X_{j\delta}}$  = Нэг жуулчинд ногдох ААНБ-ын дундаж орлого

$N$  = Аж ахуйн нэгж, байгууллагын тоо

$O_{\bar{A}i}$  = Гадаад жуулчдаас олсон ААНБ-ын орлого

$E_{\bar{A}i}$  = Гадаадаас хүлээн авсан жуулчдын тоо

$$\overline{X_{j\delta}} = \frac{O_{\bar{A}}}{E_{\bar{A}}} = \frac{\sum_{i=1}^N O_{\bar{A}i}}{\sum_{i=1}^N E_{\bar{A}i}} ; \quad (3)$$

Тооцоог хийсвэр жишээгээр үзүүлбэл: Хөвсгөл аймгийн аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг 5 аж ахуйн нэгж, байгууллагын 2007 оны 3 дугаар улирлын мэдээ ирсэн гэж үзье.

ААНБ-ын нэр	Гадаадын жуулчдаас олсон орлого (мян.төг)	Гаднаас хүлээн авсан жуулчдын тоо
Хөвсгөл трэйвэл	12600	150
Хөвсгөл жуулчин	16800	200
Ургах наран	26400	500
Монголын нүүдэлчин ХХК	54600	800
Монгол угсаа ХХК	62800	1050

Дээрх мэдээг үндэслэн Хөвсгөл аймгийн гадаадын нэг жуулчинд ногдох аж ахуйн нэгж, байгууллагын дундаж орлогыг тодорхойлбол:

$$\overline{X_{j\delta}} = \frac{O_{\bar{A}}}{E_{\bar{A}}} = \frac{\sum_{i=1}^5 O_{\bar{A}i}}{\sum_{i=1}^5 E_{\bar{A}i}} = \frac{12600 + 16800 + 26400 + 54600 + 62800}{150 + 200 + 500 + 800 + 1050} = \frac{173200}{2700} = 64.1 \text{ мянган төгрөг}$$

Хөвсгөл аймгийн 2007 оны 3 дугаар улиралд гадаадын нэг жуулчинд ногдох аж ахуйн нэгж, байгууллагуудын дундаж орлого 64.1 мянган төгрөг байна.

3.16. Аялал жуулчлалын аж ахуйн нэгж, байгууллагын дотоодын жуулчдаас олсон орлого -д аялал жуулчлалын аж ахуйн нэгж, байгууллагын дотоодын жуулчдад үйлчилгээ үзүүлж олсон орлогыг оруулна.

Энэ үзүүлэлтийг аялал жуулчлалын салбарын үйл ажиллагааны улирал, жилийн албан ёсны статистик (“Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын 20.. оны мэдээ”-АЖ-1, “Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын 20.. оны ... –р улирлын мэдээ”-АЖ-1а) мэдээллээс нэгтгэн гаргана.

3.17. Дотоодын нэг жуулчинд ногдох аялал жуулчлалын аж ахуйн нэгж, байгууллагын дундаж орлого -д тайлант хугацаанд дотоодын жуулчдаас олсон аж ахуйн нэгж, байгууллагын нийт орлогын хэмжээг тухайн хугацаанд үйлчилгээ авсан нийт дотоодын жуулчдын тоонд харьцуулж дотоодын нэг жуулчинд ногдох ААНБ-ын дундаж орлогыг тооцно.

Энэ үзүүлэлтийг тооцоход шаардлагатай дотоодын жуулчдаас олсон нийт орлого болон нийт дотоодын жуулчдын тоог аялал жуулчлалын салбарын үйл ажиллагааны улирал, жилийн албан ёсны статистик (“Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын 20.. оны мэдээ”-АЖ-1, “Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын 20.. оны ... –р улирлын мэдээ”-АЖ-1а) мэдээллээс авч тооцно.

Дотоодын нэг зочинд ногдох ААНБ-ын дундаж орлогыг (4) томъёогоор тодорхойлно. Үүнд:

$\overline{X_{\bar{A}/\bar{I}\delta}}$  = Дотоодын нэг зочинд ногдох ААНБ-ын дундаж орлого

$N$  = Аж ахуйн нэгж, байгууллагын тоо

$O_{\bar{A}i}$  = Дотоодын жуулчдаас олсон ААНБ-ын орлого

$E_{\bar{A}i}$  = Дотоодын жуулчдын тоо

$$\overline{X_{\bar{A}/\bar{I}\delta}} = \frac{O_{\bar{A}}}{E_{\bar{A}}} = \frac{\sum_{i=1}^N O_{\bar{A}i}}{\sum_{i=1}^N E_{\bar{A}i}}; \quad (4)$$

Тооцоог хийсвэр жишээгээр үзүүлбэл: Хөвсгөл аймгийн аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг 5 аж ахуйн нэгж, байгууллагын 2007 оны 3 дугаар улирлын мэдээ ирсэн гэж үзье.

ААНБ-ын нэр	Дотоодын жуулчдаас олсон орлого (мян.төг)	Дотоодын жуулчдын тоо
Хөвсгөл трэйвэл	12600	120
Хөвсгөл жуулчин	16800	160
Ургах наран	26400	250
Монголын нүүдэлчин ХХК	54600	520
Монгол угсаа ХХК	62800	598

Дээрх мэдээг үндэслэн Хөвсгөл аймгийн дотоодын нэг жуулчинд ногдох аж ахуйн нэгж, байгууллагын дундаж орлогыг тодорхойлбол:

$$\overline{X_{\dot{A}/\dot{I}\delta}} = \frac{O_{\dot{A}}}{E_{\dot{A}}} = \frac{\sum_{i=1}^5 O_{\dot{A}i}}{\sum_{i=1}^5 E_{\dot{A}i}} = \frac{12600 + 16800 + 26400 + 54600 + 62800}{120 + 160 + 250 + 520 + 598} = \frac{173200}{1648} = 105.1 \text{ Мянган төгрөг}$$

Хөвсгөл аймгийн аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагуудын 2007 оны 3 дугаар улиралд дотоодын нэг жуулчинд ногдох ААНБ-ын дундаж орлого 105.1 мянган төгрөг байна.

3.18. Аялал жуулчлалын зардал гэж Монгол Улсаас бусад улс руу аялсан жуулчдаас гадаадын тээвэрлэгчид /олон улсын үндэсний тээвэрт/ төлсөн төлбөрийг оролцуулахгүйгээр аялж буй орноос аливаа үйлчилгээ болон бараа бүтээгдэхүүн худалдан авахад зориулан зарцуулсан мөнгөний хэмжээг хэлнэ.

Аялал жуулчлалын зардлыг хоёр төрлөөр тодорхойлно. Үүнд аялал жуулчлалын нийт зардал болон аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын нийт зардлын жуулчидтай холбоотой зардал гэж ялган тооцно. Эдгээр зардлыг дараахь байдлаар тодорхойлно.

1. Аялал жуулчлалын нийт зардлыг Монгол Улсаас бусад улс руу аялсан жуулчдын тоо, тухайн улсад өнгөрөөсөн дундаж хугацаа, өдөрт зарцуулсан мөнгөний дундаж хэмжээ гурвын үржвэр дүнгээр гаргана.
2. Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын нийт зардлын жуулчидтай холбоотой зардлыг эдгээр аж ахуйн нэгж, байгууллагын улирлын болон жилийн мэдээнээс авч нэгтгэн гаргана.

Аж ахуйн нэгж, байгууллагын жуулчдад зарцуулсан зардлыг аялал жуулчлалын салбарын үйл ажиллагааны улирал, жилийн албан ёсны статистик ("Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын 20.. оны мэдээ"-АЖ-1, "Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын 20.. оны ... –р улирлын мэдээ"-АЖ-1а) мэдээллээс нэгтгэн гаргах бол аялал жуулчлалын нийт зардлыг түүвэр судалгааны үр дүнгээр тооцно.

3.19. Аялал жуулчлалын аж ахуйн нэгж, байгууллагын Монголд аялуулсан аяллын нэг жуулчинд ногдох дундаж зардал гэж тайлант хугацаанд Монголд аялуулсан аялалд зарцуулсан ААНБ-ын нийт зардлын хэмжээг тухайн хугацаанд үйлчилгээ авсан дотоодын жуулчдын тоо, гадаадаас хүлээн авсан жуулчдын тооны нийлбэрт харьцуулж ААНБ-ын Монголд аялуулсан аяллын нэг жуулчинд ногдох дундаж зардлыг тооцно.

Энэ үзүүлэлтийг тооцоход шаардлагатай Монголд аялуулсан аялалд зарцуулсан нийт зардал, дотоодын жуулчдын тоо, гадаадаас хүлээн авсан жуулчдын тоог аялал жуулчлалын салбарын үйл ажиллагааны улирал, жилийн албан ёсны статистик ("Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын 20.. оны мэдээ"-АЖ-1, "Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын 20.. оны ... –р улирлын мэдээ"-АЖ-1а) мэдээллээс авч тооцно.

ААНБ-ын Монгол улсад аялуулсан аяллын нэг жуулчинд ногдох дундаж зардлыг (5) томъёогоор тодорхойлно. Үүнд:

$\overline{X}_{i / \zeta_{\text{ад}}}$  = Монгол улсад аялуулсан аяллын нэг жуулчинд ногдох дундаж зардал

$N$  = Аж ахуйн нэгж, байгууллагын тоо

$Z_{Mi}$  = Монголд аялуулсан аялалд зарцуулсан ААНБ-ын зардал

$E_{\bar{A}i}$  = Дотоодын жуулчдын тоо

$E_{\bar{A}i}$  = Гадаадаас хүлээн авсан жуулчдын тоо

$$\overline{X}_{i / \zeta_{\text{ад}}} = \frac{\sum_{i=1}^N Z_{Mi}}{\sum_{i=1}^N (E_{\bar{A}i} + E_{\bar{A}i})}; \quad (5)$$

Тооцоог хийсвэр жишээгээр үзүүлбэл: Хөвсгөл аймгийн аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг 5 аж ахуйн нэгж, байгууллагын 2007 оны 3 дугаар улирлын мэдээ ирсэн гэж үзье.

ААНБ-ын нэр	Монголд аялуулсан аялалд зарцуулсан зардал (мян.төг)	Дотоодын жуулчдын тоо	Гадаадаас хүлээн авсан жуулчдын тоо
Хөвсгөл трэйвэл	26800	120	150
Хөвсгөл жуулчин	35900	160	200
Ургах наран	54950	250	500
Монголын нүүдэлчин ХХК	79200	520	800
Монгол угсаа ХХК	102600	598	1050

Дээрх мэдээг үндэслэн Хөвсгөл аймгийн ААНБ-ын Монголд аялуулсан аяллын нэг жуулчинд ногдох дундаж зардлыг тодорхойлбол:

$$\begin{aligned} \overline{X}_{i / \zeta_{\text{ад}}} &= \frac{\sum_{i=1}^N Z_{Mi}}{\sum_{i=1}^N (E_{\bar{A}i} + E_{\bar{A}i})} = \frac{\sum_{i=1}^5 Z_{Mi}}{\sum_{i=1}^5 (E_{\bar{A}i} + E_{\bar{A}i})} = \frac{26800 + 35900 + \dots + 102600}{(120 + 150) + (160 + 200) + \dots + (598 + 1050)} \\ &= \frac{299450}{4348} = 68.9 \text{ мянган төгрөг} \end{aligned}$$

Хөвсгөл аймгийн 2007 оны 3 дугаар улиралд аж ахуйн нэгж, байгууллагын Монголд аялуулсан аяллын нэг жуулчинд ногдох дундаж зардал 68.9 мянган төгрөг байна.

3.20. Аялал жуулчлалын аж ахуйн нэгж, байгууллагын гадаадад аялуулсан аяллын нэг жуулчинд ногдох дундаж зардал гэж тайлант хугацаанд гадаадад аялуулсан аялалд зарцуулсан ААНБ-ын нийт зардлын хэмжээг тухайн хугацаанд гадаадад явуулсан жуулчдын тоонд харьцуулж ААНБ-ын гадаадад аялуулсан аяллын нэг жуулчинд ногдох дундаж зардлыг тооцно.

Энэ үзүүлэлтийг тооцоход шаардлагатай гадаадад аялуулсан аялалд зарцуулсан нийт зардал, гадаадад явуулсан жуулчдын тоог аялал жуулчлалын салбарын үйл ажиллагааны улирал, жилийн албан ёсны статистик (“Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын 20.. оны мэдээ”-АЖ-1, “Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын 20.. оны ... –р улирлын мэдээ”-АЖ-1а) мэдээллээс авч тооцно.

ААНБ-ын гадаадад аялуулсан аяллын нэг жуулчинд ногдох дундаж зардлыг (6) томъёогоор тодорхойлно. Үүнд:

$\overline{X_{\bar{A}/\zeta\alpha\delta}}$  = ААНБ-ын гадаадад аялуулсан аяллын нэг жуулчинд ногдох дундаж зардал

$N$  = Аж ахуйн нэгж, байгууллагын тоо

$Z_{\beta i}$  = Гадаадад аялуулсан аялалд зарцуулсан ААНБ-ын зардал

$E_{\beta i}$  = Гадаадад явуулсан жуулчдын тоо

$$\overline{X_{\bar{A}/\zeta\alpha\delta}} = \frac{\sum_{i=1}^N Z_{\beta i}}{\sum_{i=1}^N E_{\beta i}}; \quad (6)$$

Тооцоог хийсвэр жишээгээр үзүүлбэл: Хөвсгөл аймгийн аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг 5 аж ахуйн нэгж, байгууллагын 2007 оны 3 дугаар улирлын мэдээ ирсэн гэж үзье.

ААНБ-ын нэр	Гадаадад аялуулсан аялалд зарцуулсан зардал (мян.төг)	Гадаадад явуулсан жуулчдын тоо
Хөвсгөл трэйвэл	12600	150
Хөвсгөл жуулчин	16800	200
Ургах наран	26400	500
Монголын нүүдэлчин ХХК	54600	800
Монгол угсаа ХХК	62800	1050

Дээрх мэдээг үндэслэн Хөвсгөл аймгийн аж ахуйн нэгж, байгууллагын гадаадад аялуулсан аяллын нэг жуулчинд ногдох дундаж зардлыг тодорхойлбол:

$$\overline{X_{\bar{A}/\zeta\alpha\delta}} = \frac{\sum_{i=1}^5 Z_{\beta i}}{\sum_{i=1}^5 E_{\beta i}} = \frac{12600 + 16800 + 26400 + 54600 + 62800}{150 + 200 + 500 + 800 + 1050} = \frac{173200}{2700} = 64.1 \text{ мянган төгрөг}$$

Хөвсгөл аймгийн 2007 оны 3 дугаар улиралд аж ахуйн нэгж, байгууллагын гадаадад аялуулсан аяллын нэг жуулчинд ногдох дундаж зардал 64.1 мянган төгрөг байна.

## Ашигласан материал

1. НҮБ-ын Дэлхийн Аялал Жуулчлалын Байгууллагаас гаргасан Аялал жуулчлалын статистикийн олон улсын зөвлөмжийн анхны хувилбар-2007 (International Recommendation on Tourism Statistics The provisional draft- 2007)
2. НҮБ-ын Дэлхийн Аялал Жуулчлалын Байгууллагаас гаргасан Аялал жуулчлалын статистикийн олон улсын зөвлөмж-2000 (International Recommendation on Tourism Statistics- 2000)
3. Зам, Тээвэр, Аялал Жуулчлалын Яам, Хууль Зүй, Дотоод Хэргийн Яамнаас хамтран гаргасан Аялал жуулчлалтай холбогдсон эрх зүйн баримт бичгийн эмхтгэл-2006 он
4. OECD: Glossary of statistical terms <http://stats.oecd.org/glossary/>
5. Аялал жуулчлалын тухай хууль (Law on tourism, Mongolia)